

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ  
6 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар**

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны мэдээлэл**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 2021 оны 6 дугаар сарын 03-нын өдөр хуралдаж Тогтоолд залруулга хийх тухай, Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнуулахаар уламжлах тухай, аймгийн баяр наадмыг зохион байгуулах хүсэлт уламжилах, хороо томилох тухай, бусад асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

Мөн тус хуралдаанаар аймгийн ИТХ-ын ээлжит бус хуралдаан зарлан хуралдуулах асуудлыг хэлэлцээд 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдөр хуралдуулахаар шийдвэрлэлээ.

**Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл**

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2021 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, [unelgee.gov.mn](http://unelgee.gov.mn) Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн санд байршуулан баталгаажуулж, тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хугацаанд нь хүргүүлсэн.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 2021 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээд “бүрэн хэрэгжсэн” буюу 100 хувьтай /90-100 хүртэл хувь/ заалт 144, “хэрэгжих шатанд” буюу 70 хувьтай /50-89 хүртэл хувь/ заалт 76, “хэрэгжилт хангалтгүй” буюу 30 хувьтай /10-49 хүртэл хувь/ заалт 18, хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй заалт 9, нийт 129 шийдвэрийн 247 заалтын хэрэгжилтийн дундаж 85.1 хувьтай байна.

Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг дахь салбар зөвлөлийн 2021 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан, Архангай аймгийн төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагуудын ёс зүйн зөвлөлийн 2021 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны мэдээлэл, ёс зүйн зөвлөлд ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.

Мөн төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаал, төрийн үйлчилгээний удирдах албан тушаалын сонгон шалгаруултын захиалгыг аймгийн хэмжээнд нэгтгэн Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны 143 дугаар захирамжаар баталсан “Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумын Засаг дарга, ЗДТГ-ын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу агентлаг, сумдын 2021 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдэж байна.

Аймгийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдөр цахимаар зохион байгуулж аймгийн Засаг даргын 2020 оны А/254 дүгээр захирамжаар баталсан “Агентлаг, сумын үйл ажиллагаанд явцын үнэлгээ хийх журам”-ын дагуу агентлаг, сумдын 2021 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны явцын үнэлгээг танилцуулж, аймгийн Засаг дарга Д.Золжаргал агентлаг, байгууллага, сумдын дарга нарт цаг үеийн шинжтэй, ажил эрчимжүүлэх чиглэлээр тодорхой үүрэг даалгавруудыг өгсөн байна.

Архангай аймагт сүүлийн 24 цагт 310 хүнд PCR шинжилгээ хийгдсэнээс шинээр 39 тохиолдол илэрсэн байна. Үүнээс сүүлийн 24 цагт Чулуут-1, Тариат-12, Өлзийт-2, Өгийнуур-2, Хашаат-1, Цахир-3, Эрдэнэбулган-17, Цэцэрлэг-1 тохиолдол шинээр бүртгэгдлээ. Аймгийн хэмжээнд нийт COVID-19-ын батлагдсан тохиолдлын тоо 1455 боллоо. Сумдаар нь задалж авч үзвэл, 2020 онд Батцэнгэл-3, 2021 онд Батцэнгэл-13, Хайрхан-75, Эрдэнэмандал-60, Чулуут -52, Ихтамир -83, Цэнхэр-74, Хотонт-76, Тариат-62, Өлзийт-53, Жаргалант-15, Өгийнуур-18, Хашаат-88, Өндөр-Улаан-39,

Төвшрүүлэх-36, Хангай-7, Цахир -7, Хоршоолол-4, Эрдэнэбулган -676, Цэцэрлэг -14 тохиолдолтой байна.

Архангай аймагт COVID-19 өвчний улмаас нийт эмчлүүлж байгаа хүний тоо – 532, үүнээс эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй эмчлүүлэгчийн тоо -328, ӨЭМТ-ийн хяналтанд гэрээр эмчлэгдэж байгаа хүний тоо -204, тусгай эмнэлгүүдээс эмчлэгдэн гарсан хүний тоо 864, батлагдсан тохиолдлын ойрын хавьтлын тоо -7848, /нийт өссөн дүнгээр/, тусгаарлан ажиглах байранд байгаа иргэн байхгүй.

Батлагдсан тохиолдлын ойрын хавьтлын гэрийн тусгаарлалтанд байгаа иргэд– 2271 байна. Аймгийн хэмжээнд 23 цэгээр коронавируст халдварын эсрэг вакцинаар дархлаажуулалтыг зохион байгуулж, 2021 оны 6-р сарын 30-ны өдрийн 00.00 цагийн байдлаар I тунд – 52294, II тунд – 46131 хүн дархлаажуулалтад хамрагдаад байна.

Улсын Онцгой комиссын 2021 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 21 дүгээр хурлын тэмдэглэл, Аймгийн Онцгой комиссын 2021 оны 16 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” аймгийн Засаг даргын захирамж гарч аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэг “Улаан түвшин”-д 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 07.00 цагаас 07 дугаар сарын 10-ны өдрийн 07.00 цаг хүртэл хугацаанд шилжүүлж, Засгийн газрын 2021 оны 118 дугаар тогтоолоор баталсан “Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”-д заасан арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг агентлаг байгууллагын удирдлагууд болон сумдын Засаг дарга нарт үүрэг болгосон байна.

### **Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд Татвар төлөлт**

2021 оны 6-р сард орлогын төлөвлөгөөг хүлээгдэж буй гүйцэтгэлээр улсын төсөвт 159.6 сая төгрөг, аймгийн төсөвт 1184.6 сая төгрөг төвлөрүүлэхээр ажиллаж байна.

Цахимаар татвар төлөх талаар видео бичлэг, татварын тайлан хүргүүлэх хугацааг сануулсан, татвар хууль тогтоомжтой холбоотой 13 мэдээ, мэдээллийг Архангай аймгийн Татварын хэлтсийн пэйж хуудсанд 2 удаагийн давтамжтайгаар байршуулан, 591 хүн үзэж, 125 хүн шейр хийж, бусдад түгээсэн.

Татварын хууль тогтоомж, татварын тайлан гаргах, цахимаар татвар төлөлтийн талаар 272 татвар төлөгчид утсаар зөвлөгөө өгч, и-баримтын нэвтрэх нэр, нууц үг авах хүсэлт гаргасан 26 татвар төлөгчид нэвтрэх нэр нууц үгийг олголоо.

### **Хөрөнгө оруулалт**

2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 41.177.4 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 45 төсөл арга хэмжээ, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3.666.2 мянган төгрөгийн 28 төсөл, арга хэмжээ, авто замын сангийн хөрөнгөөр 315.0 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр тус тус батлагдсан байна.

### **Орон нутгийн өмч, худалдан авах ажиллагаа**

Орон нутгийн өмчит 26 төсөвт байгууллагад 48.2 сая төг-ийн үндсэн хөрөнгө худалдан авах зөвшөөрлийг олгож, 3 төсөвт байгууллагад 22.8 сая төг-ийн үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэх зөвшөөрлийг олгосон 21 байгууллагад 358 нэр төрлийн 351.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил актлах зөвшөөрөл олгосон.

2020 онд УТХО болон ОНТХ-өөр хэрэгжүүлэх нийт 54.5 сая төгрөгний өртөг бүхий 103 төсөл арга хэмжээний тендер зохион байгуулалтын төлөвлөгөөг Засгийн газрын цахим сайт [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)-д ил тодоор байршуулсан. Төлөвлөгөөнд тусгагдсан 103 төсөл арга хэмжээ буюу худалдан авалтыг 100 хувь зохион байгуулсан.

Улсын төсвийн хөрөнгөөр ЗГХЭГ-ын 1 тэр бум 394,0 сая төгрөгний 10 төсөл арга хэмжээ, БСШУСЯ-ны 18 тэр бум 138,6 сая төгрөгний 38 төсөл арга хэмжээ, БХБЯ-ны 4 тэр бум 680 сая төгрөгний 4 төсөл арга хэмжээ, ЭМЯ-ны 17 тэр бум 015 сая төгрөгний

2 төсөл арга хэмжээ, ЗТХЯ- ны 3 тэр бум 600,0 сая төгрөгний 3 төсөл арга хэмжээ, ХХААХҮЯ-ны 590,0 сая төгрөгний 3 төсөл арга хэмжээ, БОАЖЯ-ны 160,0 сая төгрөгний 1 төсөл арга хэмжээний худалдан авалтыг зохион байгууллаа.

Мөн улсын төсвийн хөрөнгөөр зөвлөх үйлчилгээний 923,2 сая төгрөгний 1 төсөл арга хэмжээ, ОНХСХО-аар 2,947,5 сая төгрөгний 25 төсөл арга хэмжээ, Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар 858,4 сая төгрөгний 6 төсөл арга хэмжээ, Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн хамтарсан хөрөнгө оруулалтаар 1,404,5 сая төгрөгний 5 төсөл арга хэмжээ, Захиалгат ажил 2.865,6 сая төгрөгний 1 төсөл арга хэмжээний ажлуудыг зохион байгуулсан байна. Үүнд: Тендерийн үйл ажиллагааг хялбаршуулсан цахим хэлбэрээр зохион байгуулж тендерийн урилга, баримт бичиг, үр дүнг тухай бүр цахим системд оруулан ажиллаж байна. Шилэн тендерийг хэрэгжүүлэх тухайн заавар зөвлөмжийг холбогдох төрийн болон төрийн өмчийн оролцоотой ААН-үүдийн төсөв захирагч холбогдох албан тушаалтнуудад 2-3 удаа хүргүүлж заавар зөвлөлөгөө өгсөн.

Худалдан авалтын төлөвлөлт зохион байгуулалт, тайлагналын үйл ажиллагааг сумын Санхүүгийн албаны дарга нарт хариуцуулан тэдний ажлын байрны тодорхойлолтонд тусгуулан, Мэдээ, мэдээллийг [www.arhangai.gov.mn](http://www.arhangai.gov.mn) сайт болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулан тавьж байна.

### **Санхүүгийн хяналт**

“Архангайд үйлдвэрлэв” орон нутгийн өмч аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, Цөм сүргийн үржлийн төв, Аялал жуулчлалын мэдээлэл, үйлдвэрлэлийн төвүүдэд аудит, хяналт шалгалт хийгдэж, орон нутгийн өмчийн байгууллагуудын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт хийгдлээ. Сангийн сайдын баталсан нэгдсэн удирдамжийн хүрээнд газрын нөхөн төлбөрийн ногдуулалт, төлөлтийн байдалд болон иргэний өргөдөл хүсэлтээр Эрдэнэбулган сумын ЗДТГ-т хяналт шалгалт тус тус хийгдлээ. Аудит, хяналт шалгалтаар нийт 108.2 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрч, шалгалтын явцад арилгуулах, улсын байцаагчийн актаар нөхөн төлбөр тогтоох, зөрчлийг арилгуулах хугацаатай үүрэг даалгавар өгч шийдвэрлэлээ. Одоогийн байдлаар аймагт хэрэгжиж буй хөдөө аж ахуйн төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн байдал болон Татварын хэлтсийн үйл ажиллагаанд аудит, хяналт шалгалт хийгдэж байна.

### **Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд Хууль, хяналт**

2021 оны 6 дугаар сард гамшиг, аюулт үзэгдэл, ослын нийт 5 удаагийн дуудлага мэдээлэл ирсэнээс объектын гал түймэр 4 удаа, хүний гоц халдварт өвчин 1 гарсан байна. Онцгой байдлын газрын холбооны 10 нэр төрлийн 62 техник хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийг цэвэрлэгээ, үзлэг, засварыг хийж антены бэхэлгээг давхар шалгаж, ТҮ-г хуваарийн дагуу хийж, 4 албан хаагчийн компьютерыг засварлан хэвийн ажиллагааг хангаж, гар станц болон машины станц, GPS 60CSx, сансрын IRIDIUM утас бэлтгэл бэлэн байдлыг ханган ажилласан.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу Архангай аймгийн нутаг дэвсгэрт байрлалтай Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн санал авах байруудад Гамшгаас хамгаалах болон Гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс 06 дугаар сарын 08-ний өдрийн дотор зохион байгууллаа.

2021 оны 6-р сард аймгийн хэмжээнд өссөн дүнгээр 177 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 63, хулгайлах гэмт хэрэг 47, иргэдийн өмчийн хулгайн гэмт хэрэг 11, малын хулгайн гэмт хэрэг 27, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 8, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 54, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 20, гэмт хэргийн илрүүлэлт 38.0 хувьтай байна.

Нийт 9117 захиргааны зөрчил бүртгэгдсэнээс Зөрчлийн тухай хуулийн дагуу 8672 иргэнд 341087.6 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ 401.1 сая төгрөг, нөхөн төлүүлэлт 54 8 хувьтай байна.

Шүүхийн шинжилгээний алба 6-р сард криминалистикийн шинжилгээ 3, хэргийн газрын үзлэгээр илрүүлж бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт 15, шүүх эмнэлгийн шинжилгээ 21, тусгай шинжилгээ 6-г хийсэн байна.

Мэргэжлийн хяналтын газар аймгийн Засаг даргын 2021 оны А/307, А/308, А/332 дугаар захирамжуудын хүрээнд хүнсний худалдаа, үйлчилгээний байгууллагуудын ажиллах цагийн хуваарийг тогтоож, үйлчилгээний үйл ажиллагаанд халдвар хамгааллын дэглэмийн мөрдөлтийн байдалд 500 объектыг хамруулан шалгалт хийж 307 зөрчлийг илрүүлж, 73.4 хувийг нь арилгуулан ажилласан. Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 41 дугаар тушаалаар батлагдсан тусгай нөхцөл шаардлагыг хэрэгжүүлэх талаар 90 аж ахуй нэгж, иргэн, 33 төрийн байгууллагад нийт 124 мэдэглийг хүргүүлж ажиллалаа

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх Засгийн газар, Улсын онцгой комисс, аймгийн Онцгой комисс, аймгийн Засаг даргын гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаж байна.

Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 18-р тушаалаар батлагдсан тусгай нөхцөл шаардлагыг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх талаар газрын даргын 01/64 дүгээр албан бичгийг сумдын Засаг дарга нарт хүргүүлж, орон нутгийн хэмжээнд зохион байгуулсан ажил арга хэмжээний талаар тайланг хүлээн авч биелэлтийг тооцоход 47.1 хувьтай байна.

Дулааны улирал эхэлж байгаатай холбогдуулан шар усны үер болох, улс орон нутгийн чанартай авто зам эвдрэх, айл өрх, гудамж талбай усанд автах болзошгүй осол, гэмтэл гаргахаас урьдчилан сэргийлж авто замын арчлалт, засварын ажил гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллагуудад улсын байцаагчийн зөвлөмж, үүрэг өгсөний дагуу тус аж ахуйн нэгжүүд нь А-0602 дугаартай, А-0603 дугаартай Хархорин-Цэцэрлэг-Тосонцэнгэл чиглэлийн автозамын нийт 70 ширхэг хоолойн орох гарах амсар, 317 км замын зурвас газрын хог, малын сэг зэмийг цэвэрлэж зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Барилгын ажил эхэлж байгаатай холбогдуулан аймгийн хэмжээнд барилгын угсралт, барилгын материалын үйл ажиллагаа явуулдаг тусгай зөвшөөрөл бүхий 15 аж ахуй нэгж байгууллагад барилгын угсралт, үйлдвэрлэлийн чанар, коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулахаар улсын байцаагчийн 2 төрлийн 36 заалт бүхий 15 зөвлөмжийг хүргүүлэн биелэлтэнд нь хяналт тавин ажиллаж байна.

Хөдөө аж ахуй, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн худалдан борлуулагч, малын эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэгч нарт халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэх чиглэлээр 18 заалт бүхий 2 төрлийн улсын байцаагчын зөвлөмжийг 5 аж ахуй нэгж, 136 иргэнд хүргүүлсэн байна.

Коронавирусын халдвар гарсантай холбогдуулан Чулуут, Хангай, Тариат, Хайрхан, Батцэнгэл, Эрдэнэбулган, Эрдэнэмандал, Өлзийт, Жаргалант, Өгийнуур, Төвшрүүлэх, Хотонт, Ихтамир сумдын 480 айл өрх, тусгаарлан ажиглах байр-14, 194 худалдаа үйлчилгээний газар, 502 бусад албан байгууллага, нийт 1219 объектын 159981 м.кв талбайд голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг Зооноз, өвчин судлалын төвөөр хийлгүүлж байнгын хяналтыг тавьж ажиллаж байна. Мөн халдваргүйжүүлэлтэнд ашиглаж буй бодисыг МХГ-ын итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамруулж, хлорын идэвхийг тодорхойллоо.

2021 оны 6-р сарын байдлаар өссөн дүнгээр хүнс худалдаа, үйлдвэр үйлчилгээний 378 объектын 98984 м<sup>2</sup>, 18 эрүүл мэндийн байгууллагын 6498 м<sup>2</sup>, 109 сургалт боловсролын байгууллагын 283112 м<sup>2</sup>, нийтийн эзэмшлийн гудамж талбайн 153864 м<sup>2</sup>, бусад 129 албан байгууллагын 43400 м<sup>2</sup> талбайд тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт хийсэн байдалд хяналт тавьж ажиллалаа.

Стандарт, хэмжил зүйн хэлтэст 6-р сард 2 аж ахуйн нэгж, 12 иргэний хүсэлт ирснээс худалдааны газар-5, хоолны газар-5, саун-1, жуулчны бааз, эко гэр-2 тохирлын гэрчилгээ сунгуулах болон шинээр авах хүсэлт ирүүлсэн байна. Нийт 13 үйлчилгээ, 1 бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ олгосон байна.

Цэнхэр, Эрдэнэбулган, Өндөр-Улаан, Тариат, сумдын 11 ШТС-ын 22 шатахуун түгээгүүрийн 41 шингэн хэмжигч / түгээх хошууг / баталгаажуулалтад хамруулсан.

“ЭБЦТС” ТӨХК-тай хамтран ээлжит баталгаажуулалтын ажлаар 1 фазын тоолуур 6 ширхэг, 3 фазын тоолуур 2 ширхэг, нийт 8 ширхэг хэмжих хэрэгсэл баталгаажуулж улсын баталгаат гэрчилгээ олгож ажилласан байна.

Жил бүрийн 6 дугаар сарын 9-ний өдрийг “Дэлхийн итгэмжлэлийн өдөр” болгон тунхаглаж, Олон улсын итгэмжлэлийн форум (IAF), Олон улсын лаборатори итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага (ILAC)-аас итгэмжлэлийн үйл ажиллагааны ач холбогдлыг таниулах нэгэн сэдвийн дор тэмдэглэн өнгөрүүлдэг бөгөөд энэ жил НҮБ-ийн “Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг Итгэмжлэлээр дэмжих нь” сэдвийг онцолсон байна.

Энэ өдрийг тохиолдуулан аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс нь аймгийн Мал эмнэлгийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Газрын харилцаа, барилга, хот байруулалтын газар, Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн лабораториудтай хамтран онлайн уулзалт зохион байгуулж, байгууллагууд лабораториудынхаа үүсэл, ажлын чиглэл зэргийг бусад байгууллагуудад танилцуулж, лабораторийн итгэмжлэлд хамрагдахад тулгамдаж буй асуудлууд болон “Итгэмжлэлийн өдөр”-ийг цаашдаа хэрхэн тэмдэглэж байх талаар санал бодлоо солилцож хамтран ажиллах талаар хэлэлцсэн байна..

## **Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд**

### **Боловсрол**

2020-2021 оны хичээлийн жил дуусч байгаатай холбогдуулан 9, 12-р анги төгсөгчдөд суурь бүрэн дунд боловсролын гэрчилгээ олгох ажлыг амжилттай зохион байгууллаа. Архангай аймагт суурь боловсролын 1400, бүрэн дунд боловсролын 1099 гэрчилгээг хэвлэн олголоо.

Элсэлтийн ерөнхий шалгалтад 12-р ангийн сурагчдыг бэлдэх ажлыг 5 сарын 17-ноос 6 сарын 17-ны өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан 6 сарын 17-ны өдрөөс цахим хэлбэрт шилжүүлэн ажиллаж байна.

Хичээлийн жилийн хаалт, шинэ хичээлийн жилийн бэлтгэл ажилтай холбогдуулан БШУЯамнаас онлайн хурал, зөвлөгөөнийг зохион байгуулан ажиллав.

Элсэлтийн ерөнхий шалгалтын бэлтгэл ажлыг хангаж байна. Архангай аймагт ЭЕШ-аар тухайн оны төгсөгч 948, өмнөх оны төгсөгч 171 хүүхэд давхардсан тоогоор ЭЕШ-ын 10 хичээлээр 3068 шалгалт өгнө. Архангай аймагт ЭЕШ-ыг 11 зохион байгуулагч, Боловсролын үнэлгээний төвийн 4 төлөөлөгч, 46 хянагч багш ажиллана.

### **Эрүүл мэнд**

Сумын эрүүл мэндийн төвүүдэд шүдний кабинет байгуулан ажиллуулахад тавигдах шаардлага, үнэлгээний хуудсаар үнэлгээ хийж, шаардлага хангасан Батцэнгэл, Төвшрүүлэх сумын эрүүл мэндийн төвд шүдний кабинет байгуулах саналыг ЭМЯ-нд хүргүүлсний дагуу 102 сая төгрөгний шүдний иж бүрэн тоног төхөөрөмжийг тус 2 эрүүл мэндийн төвд суурилуулсан.

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/369 дүгээр тушаалаар Булган сумын Эрүүл мэндийн төвийн гаднах бохир цэвэр усны байгууламжийн засвар үйлчилгээнд 54,5 сая төгрөг шийдвэрлэгдэн аймгийн Засаг даргад эрх шилжүүлэн ирүүлсэн. Тус засварын зураг төсөв болон гүйцэтгэгч шалгаруулах тендер зарлуулах бэлтгэл ажил хийгдэж байна.

Эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадвхижуулах ажлын хүрээнд Нэгдсэн эмнэлгийн 1 их эмчийг УНТЭ-т 14 хоногоор дадлагажуулан суралцуулж, Zoom

холболтыг ашиглан 12 удаа шуурхай хурал, хэлэлцүүлэг, сургалтыг хийж 158 эмнэлгийн ажилтанг хамруулсан.

Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагааны зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дуусаж багц цаг бүрдүүлэлтээр хугацаа сунгуулах хүсэлт гаргасан 19 эмнэлгийн мэргэжилтэн, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн шалгалтад тэнцсэн 25 эмнэлгийн мэргэжилтний материалыг ЭМХТ-д уламжилсан.

Төрийн албанаас өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгоход шаардагдах хөрөнгийг 33 хүний 691328.3 мянган төгрөгийг 2021 оны төсөвт тусган материал ирүүлсний дагуу ЭМЯ-ны албан бичгийг үндэслэн 5 хүнд 85 361 900 төгрөгний тэтгэмжийг олгож байна.

Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны А/28 дугаар тушаалын дагуу “КОВИД-19” цар тахлын тусгай эмнэлэгт нийт 80 гаруй эмнэлгийн ажилтан томилогдон ажилласан. Үүнээс гадна сорьц тээвэрлэхэд 82, PCR шинжилгээ хийхэд 12 ажилтан ажилласан.

Эрүүл мэндийн ажилтнууд халдвар авч, эмнэлгийн ажилчид ойрын хавьтлаар тогтоогдон тусгаарлагдаж байгаатай холбоотой эрүүл мэндийн байгууллага хооронд эмнэлгийн ажилчдыг дайчлан Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар их эмчийн 18, сувилагчийн 20, үйлчлэгчийн 20 ээлжийг гарган баталгаажуулан, мөрдлөг болгон ажиллаж байна.

15486 хүнийг PCR шинжилгээнд, 3666 хүнийг түргэвчилсэн шинжилгээнд хамруулснаас 919 батлагдсан тохиолдлыг илрүүлж, эмчилгээнд хамруулсан.

Батлагдсан тохиолдлуудын тандалт судалгааг хийж, 3874 хавьтлыг тогтоож, гэрийн тусгаарлалтад авч, хянасан.

Вакцинжуулалтын 23 цэгт коронавирусийн эсрэг вакцинжуулалтын 1 дүгээр тунд 2880, 2 дугаар тунд 33701 хүнийг хамруулсан.

Эрдэнэбулган сумын хяналтын постуудаар нэвтэрч байгаа иргэдийн эрүүл мэндийг тандах үйл ажиллагаанд 76 эрүүл мэндийн ажилтан ажиллаж, 8000 гаруй иргэний эрүүл мэндийг байдлыг тандсан.

Жаргалант, Ихтамир, Чулуут, Өндөр-Улаан, Төвшрүүлэх, Хотонт сумын халдварын голомтуудад газар дээр нь очиж ажиллан, тандалт судалгаа хийж, мэргэжил аргагүйн зөвлөгөө өгсөн.

Гэрийн эмчилгээг TANDALT.GOV.MN систем, HINFO програмд хэрхэн талаар өрхийн эрүүл мэндийн төвүүдэд сургалт хийн, нэвтрүүлсэн.

TANDALT.GOV.MN системд батлагдсан тохиолдолын ойрын хавьталуудын мэдээлэл, тусгаарлах байранд байгаа иргэдийн мэдээлэл оруулсан.

### **Соёл урлаг**

Аймгийн Нийтийн номын сан улс орон даяар “Covid-19” цар тахлын тархалт нэмэгдэж, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан гэрээр ном олголтоор 6 угшигч 20 ирэгсэдэд 55 ном олгож үйлчилсэн. 30 ирэгсэдэд 120ш тогмол хэвлэлийг гэрээр олгосон.

Архангай аймгийн ахмадийн хороо, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, “Булган” МСҮТ, Онцгой байдлын газар, Татварын хэлтэс, Эрдэнэбулган сумын 2-р баг гэсэн 5 байгууллагад зөөврийн номын сангийн үйлчилгээ гэрээний дагуу хүрч 12 сараас 6–р сар хүртэл нийт 135 уншигчдад 215 номоор үйлчилсэн.

Номын сангийн MonKoha үүлэн технологийн программд ном шивэх ажлыг эрчимжүүлэх зорилтын хүрээнд үндсэн фондын 256 нэрийн 600 ширхэг номыг шивж, бар коджуулж, үндсэн фондын 605 нэр төрлийн 1925 ширхэг номыг хуучин данстай тулгаж, номыг нэг бүрчилсэн бүртгэлд стандартын дагуу шинэчлэн хуулж бүртгэсэн байна.

Аймгийн Хөгжимт драмын театр аймгийн АВ телевизтэй хамтран байгууллагын төлөвлөгөөт шинэ уран бүтээл болох “Ардын хувьсгалын 100” жил аймаг байгуулагдсны 98 жилийн ойн баяр наадамд зориулсан шинэ уран бүтээлийн тоглолтыг видео бичлэг болгохоор бэлтгэн ажиллаж байна.

## **Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал**

2021 оны 6-р сарын байдлаар Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMS программд ажил идэвхитэй хайгч 1346 иргэн бүртгэлтэй байгаагаас 660 эмэгтэй. Шинэ ажлын байр **509** үүнээс байнгын ажлын байр 279, улирлын ажлын байр 99, түр ажлын байр 131 байна. Ажил олгогч байгууллагуудаас ирүүлсэн ажлын байрны захиалга 409, зуучлал 396 байна. Тухайн сарын 20-ны байдлаар 87 иргэн нь шинээр бүртгүүлж, LMS программд шивж оруулсан. Ажил идэвхитэй хайгч иргэдийг боловсролын түвшингээр ангилвал: боловсролгүй- 9, бага- 68, суурь-228, бүрэн дунд- 814, техникийн болон мэргэжлийн анхан шатны – 29, тусгай мэргэжлийн дунд-26, Дипломын бакалаврын-172 иргэнийг тус тус бүртгэж мэдээллийн бааз үүсгэн ажилласан байна. Тухайн сард ажилгүйдлийн тэтгэмж авахаар ирсэн 6 иргэнийг LMS програмд шивж оруулан тодорхойлолт гарган өгч НДХэлтэс рүү хүргүүлсэн байна.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч 40 иргэнд 150.0 сая төгрөгийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг олгож, 40 ажлын байр шинээр бий болгосон байна.

Тус хөтөлбөрийн “Малчдыг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ”-ний хүрээнд Чулуут, Тариат, Өндөр-Улаан, Цэцэрлэг, Хайрхан, Өгийнуур, Хотонт, Цэнхэр, Төвшрүүлэх, Булган зэрэг 10 сумын 21 малчин өрхийг малжуулж 93.0 сая.төгрөгийг зарцууллаа.

Нийтийг хамарсан ажлын хүрээнд нийтийн эзэмшлийн өмч хөрөнгө, дэд бүтцийг сайжруулах, орчны хог хаягдал цэвэрлэх, нийтийн эзэмшлийн гудамж талбайн ногоон байгууламжийг сэргээн засах зэрэг ажилд ажилгүй 160 иргэнийг хамруулж түр ажлын байраар хангаж 42.0 сая төгрөгийн цалин хөлсийг олгож, өрхийн орлогыг нэмэгдүүлсэн.

Тус хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан аж ахуй, өрхийн үйлдвэрлэл эрхлэгч 40 иргэнийг аж ахуй эрхлэлтийн сургалтад хамруулж 12.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хувиараа хөдөлмөр эрхлэгч хөгжлийн бэрхшээлтэй иргэн, байнгын асаргаанд байдаг хүүхдээ хардаг 19 иргэнд 50% нь эргэн төлөгдөх нөхцөлтэй 76.0 сая.төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгож 19 иргэн ажлын байртай боллоо.

Хөгжлийн бэрхшээлтэй 20 иргэнийг аж ахуй эрхлэлтийн сургалтад хамруулж бизнес эхлэх, хөгжүүлэх, аж ахуй эрхлэх төсөл, төлөвлөгөө боловсруулах ур чадварт сурган 0.8 сая.төгрөг зарцуулсан.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд гарааны бизнес эрхлэх хүсэлтэй 90 залууг бүртгэн, 42 залууг гарааны бизнесийг дэмжих арга хэмжээний сургалтад хамрууллаа.

Шинэ технологи, инноваци бүхий шинэлэг санал, санаачлага гаргаж аж ахуй эрхлэх төсөл боловсруулсан шилдэг “Старт-ап” 3 залуу, залуусын бүлгийг шалгаруулж, хурдасгуур хөтөлбөрт хамруулж байна.

Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хувиараа хөдөлмөр эрхлэгч 15 ахмадад өрхийн үйлдвэрлэл эрхлэхэд нь зориулж 24 сарын хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийг олгож 27.0 сая төгрөг зарцууллаа.

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ үзүүлэх арга хэмжээний хүрээнд боловсрол, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, төрийн захиргааны чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээ 12 ахмад мэргэжилтэн хэрэгжүүлж байна.

Нийгмийн даатгалын гар утасны аппликейшн, “Даатгуулагчид зориулсан вэб ”-ээс цахим нийгмийн даатгалын дэвтэр, тэтгэвэр тогтоололтын хуудсыг байршуулсан ба иргэд, даатгуулагчдыг шимтгэл төлөлтийн болон тэтгэврийн тогтоололтын мэдээллээ харах, хэвлэх боломжийг бүрдүүлсэн.

Нас барсан 299 тэтгэвэр авагчийн үнэт цаасыг тарааж өвлөх эрхийн гэрчилгээ авах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

2021 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг ажил олгогч, даатгуулагч бүр 1 функтээр нэмэгдүүлэн, нийт 626 ажил олгогч, 13569 даатгуулагч шимтгэлээ тооцон төлсөн байна.

Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийг хэрэгжилтийг зохион байгуулан ажил олгогч, түүнд ажиллагсад 275.9 сая төгрөгийн, сайн дурын даатгуулагчдад 346.3 сая төгрөгийн чөлөөлөлтийг бүртгэсэн байна.

2021 оны 5-р сарын байдлаар нийт 16457 тэтгэвэр, тэтгэмж авагчдад 33.1 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийн хуулийн хугацаанд шуурхай олгож ажилласан байна.

### **Гэр бүл, хүүхэд, залуучууд**

“Нэгдүгээрт хүүхэд” үндэсний хөдөлгөөний хүрээнд “ажилтныхаа хүүхдийн төрсөн өдрөөр цалинтай чөлөө өгөх” уриалгыг байгууллагуудад хүргүүлж ажилласнаар одоогийн байдлаар 16 байгууллага нэгдээд байна.

Хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс болон осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хүмүүжүүллийн эерэг арга, хүүхэд хүмүүжүүлэх ардын ухаан, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхдийн хөгжил оролцоог дэмжих, нас сэтгэл зүйн онцлогт тохируулах хүүхэдтэй харилцах арга зүй, ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, хүүхдээ хамгаалах зэрэг ерөнхий сэдвүүдийн хүрээнд 50 постер зөвлөмжийг бэлтгэн нийтэлж, олон нийтэд хүргэсэн.

Түр хамгаалах байраар үйлчлүүлсэн 3 насанд хүрэгч, 4 хүүхдэд нийт 15 удаагийн сэтгэл зүйн зөвлөгөө мэдээлэл өгж ажилласан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн А/74 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралтыг үндэслэн 7 үйлчлүүлэгчид сэтгэл зүйн дүгнэлт гаргасан. Сэтгэл зүйн зөвлөгөө мэдээлэл авснаар үйлчлүүлэгчид өөрт тулгарч байгаа асуудлаа тодорхойлох шийдвэрлэх, өөртөө итгэх итгэл нэмэгдэх, гэр бүлтэйгээ харилцах харилцааны эв дүй нэмэгдэх, өөрт төрж буй таагүй мэдрэмжээ гадагшлуулах, асуудлыг эерэгээр шийдвэрлэх чадвар нэмэгдсэн.

Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ гэр бүлд зөвлөгөө өгөх төвд тавигдах нийтлэг шаардлага MNS 6417:2013 стандартын дагуу Гэр бүлд зөвлөгөө өгөх төв нь 6 насанд хүрэгч, 3 хүүхэд, нийт 9 иргэнд давхардсан тоогоор 30 удаагийн сэтгэл зүйн зөвлөгөө, мэдээлэл өгсөн. Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан ковид-19 өвчнөөр өвдөн эмчлүүлсэн нийт 120 иргэнд утсаар сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө, мэдээлэл өгсөн. Үүнээс 95 насанд хүрэгч, 25 хүүхэд байсан. Нийт 129 үйлчлүүлэгчид сэтгэл зөвлөгөө /анхан шатны/ өгж ажилласан. Архангай аймгийн Гэр бүлд зөвлөгөө өгөх төвийн пейж хуудсаар дамжуулан 30 удаагийн гэр бүл, эцэг эх, харгалзан дэмжигч, асран хамгаалагчид зориулсан сэтгэл зүйн цахим мэдээлэл оруулж, 25600 хүн хандсан байна.

### **Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд Мал аж ахуй**

Архангай аймгийн хэмжээнд 2021 онд төллөвөл зохих 1983.6 мянган толгой эх мал тоологдсоноос 85.3 хувь буюу 1855.3 мянган толгой эх мал төллөж 1738.1 мянган толгой төл малыг 94 хувьтай бойжуулсан.

Үүнээс нийт төллөвөл зохиох эх малыг төрөл тус бүрээр авч үзвэл нийт ингэний 68.8 хувь буюу 236 толгой ингэ, нийт гүүний 82.3 хувь буюу 81.4 мянган толгой гүү, нийт үнээний 81.7 хувь буюу 160.8 мянган толгой үнээ, нийт эм хонины 96.1 хувь буюу 1080.2 мянган толгой эм хонь, нийт эм ямааны 94.5 хувь буюу 532.7 мянган толгой эм ямаа тус тус төллөсөн байна.

Энэ оны хаврын 3-5 саруудад нийт нутгаар орсон цасан шуурга хүйтэн салхины улмаас мал их муудаж нийт мал сүргийн 2.2 хувь буюу 117.8 мянган толгой мал зүй бусаар хорогдоод байна.

Ажлын хэсэг 2 удаа хуралдаж “Нэг айл-нэг өвөлжөө-10 ар газар” арга хэмжээг хэрэгжүүлэх хөтөлбөрийг боловсруулах, малын тэжээл тариалах тариалангийн газрын асуудлыг шийдвэрлэх, хөрөнгө санхүүгийн тооцоо гаргах, хөтөлбөрт орон нутгийн удирдлага, малчдын санал хүсэлтийг тусгах асуудлуудыг хэлэлцсэн. Мөн аймгийн сумдыг 5 бүс болгон хуваан бүс тус бүр дээр үзүүлэх технологийн сургалтыг зохион

байгуулж, малчид иргэдийн санал хүсэлтийг авах, мөн сумдад төвлөрсөн тариалангийн талбайд нэгдсэн журмаар, боломжтой айл өрхийн өвөлжөө, хаваржааны бууцанд малын тэжээл тариалах зардлын тооцоог гаргаж, үр, шатахуун, техникийн асуудлыг судалж танилцуулсан. Хөтөлбөрийг боловсруулан Архангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нэртэй пейж хуудсанд байршуулан 1969 иргэн, малчдаас санал авах ажлыг цахимаар зохион байгуулсан.

“Нэг айл-нэг өвөлжөө-10 ар газар” арга хэмжээг хэрэгжүүлэх хөтөлбөрийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулахаар хүргүүлсэн.

Улсын төсвийн хөрөнгөөр Ихтамир, Хотонт сумын 8000 толгой хонь, Өндөр-Улаан, Чулуут, Тариат сумдын 4000 толгой сарлаг нийт 12000 толгой үржлийн малд үзлэг ангилалт хийж цөм сүрэг бүрдүүлэх, цөм сүргийн малтай өрхийг баталгаажуулж гэрчилгээ олгох ажлыг зохион байгуулж 4 мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан ажлыг эхлүүлж 3500 толгой малыг бүртгэлжүүлээд байна.

Бэлчээрийг хамгаалах, нөхөн сэргээх, бэлчээрийн ургамал хөрсөнд хөнөөл учруулж буй үлийн цагаан оготной тэмцэх ажлыг Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн сайдын 2021 оны А/76 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2021 оны А/238 дугаар захирамжаар батлагдсан удирдамж зааврын дагуу микробиологийн аргаар Өгийнуур сумын 5000 га, Батцэнгэл сумын 2500 га, Хашаат сумын 5000 га, Хангай сумын 2500 га, нийт 4 сумын 15000 га бэлчээрийн талбайд технологийн хугацаанд нь зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Үлийн цагаан оготной тэмцэх ажлыг 4 сумын 14 багийн оготнын тархалт ихтэй 15000 га бэлчээрийн талбайд 30 тн бактержуулсан бэлдмэлийг /будaa/ цацах ажлыг 43 автомашин, 22 мотоцикл, 79 төрийн албан хаагч, 14 ажил идэвхтэй хайж буй иргэн, 477 малчинтай хамтран үр дүнтэй зохион байгууллаа.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 01 дүгээр албан даалгавар, “Сэг, зэм устгах тухай” аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн А/117 дугаар захирамжийн дагуу аймгийн хэмжээнд том малын зүй бус хорогдлоор тэмээ 34, адуу 4988, үхэр 15284, хонь 44208, ямаа 32544 нийт 97058 толгой мал хорогдсоноос 77431 малын сэг зэмийг устгалын нүхэнд цуглуулан булах болон шатаах аргаар устгаж, нийтийн эзэмшлийн талбай-77574 м<sup>2</sup>, хашаа хороо-52918<sup>2</sup>, өтөг бууц-13770м<sup>2</sup>, худаг уст цэг-8582 м<sup>2</sup>, бэлчээр-12670м<sup>2</sup> агуулах зоорь, түүхий эд агуулах зоорь- 3808м<sup>2</sup>, устгалын цэг-12545м<sup>2</sup>, нийт 181867 м<sup>2</sup> талбайд халдваргүйтгэлийн ажил хийгдсэн. Ажлын явц 80.0 хувьтай хийгдэж байна. Энэ ажлын хүрээнд 257 хүн, 50 машин техник дайчлан ажиллаж байна.

### **Газар тариалан**

Аймгийн хэмжээнд 2021 онд улаанбуудай 9818 га-д, арвай 40 га-д, хошуу будаа 165 га-д, төмс 344 га-д, хүнсний ногоо 250 га-д, жимс, жимсгэнэ 66,5 га-д, тосны ургамал 210 га-д, малын тэжээл 1000 га-д, нийт 11893 га талбайд тариалалт хийж хаврын хаврын тариалалт 88 хувьтай байгаа бөгөөд малын тэжээлийн тариалалт ид явагдаж байна.

Нийт 2,340.6 мянган төгрөгийн 11 нэр төрлийн 620,6 кг үрийг Хөдөө аж ахуйг дэмжих сангаас татан авч, захиалсан иргэдэд нийлүүлсэн.

11 төрлийн таримлын гарын авлагыг 209 ширхгийг хэвлэн сумын мэргэжилтнүүдэд хүргүүлсэн.

4 сумын 13 иргэний 432 м<sup>2</sup> зуны хүлэмжийн захиалгыг Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яам, Хөдөө аж ахуйг дэмжих санд албан бичгээр хүргүүлээд байна.

Орон нутгийн төсвөөс 39.0 сая, төсөл хөтөлбөрөөс 91.0 сая, нийт 130.0 сая төгрөгийн санхүүжилтээр баригдах 50 тн багтаамжтай ногооны зоорины тендерийг зарласан. Мөн 23 сая төгрөгийн өртөгтэй /6,9 сая орон нутгийн хөрөнгө, 16,1 сая төсөл хөтөлбөр/ хүлэмжийн ногоо услах зориулалттай худгийн ажлын тендер зарлагдаж дуусаад, худаг ухах ажил эхэлж байна.

Хашаат, Чулуут сумын Эрүүл мэндийн төв 240 м<sup>2</sup> нарлаг хүлэмж, Эрдэнэбулган сумын 1-р сургууль 60 м<sup>2</sup>, Тариат сумын Мөрөн багийн бага сургууль 60 м<sup>2</sup> хүлэмжинд нарийн ногоо тариалж байна.

## **Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд**

### **Барилга, дэд бүтэц**

Архангай аймагт 2021 ийг үеэс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт 171 тэрбум 866.2 сая төгрөгийн өртөг бүхий 69 төсөл арга хэмжээний захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхээр төлөвлөөд ажиллаж байна. 2021 оны 6-р сард дараах ажлуудыг хэрэгжүүллээ. Үүнд: 3-р Сургуулийн урлаг заалны өргөтгөлийн барилгад комисс ажиллаж байнгын ашиглалтад оруулав. Төрийн үйлчилгээний нэгдсэн төв байгуулах засварын ажил, Тариат сумын сургуулийн их засварын ажил, Чулуут сумын сургуулийн их засварын ажил, ГБХЗХГ-ын ариун цэврийн байгууламж, гадна бохирын шугамын засварын ажил, Өлзийт сумын цэцэрлэгийн дээврийн засварын ажил, Эрдэнэбулган сумын 1-р сургуулийн дотор халаалт, усан хангамж ариутгах татуургын шугам солих ажил, Ихтамир сумын Засаг даргын Тамгын газрын барилгын засварын ажлууд тус тус эхэлсэн.

2021 оны 6-р сард аймгийн засаг даргын 25 удаагийн газартай холбоотой захирамж, шийдвэр гарсан. Үүнд: газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэх тухай 25 иргэн, ААНБ-ын 41523 м<sup>2</sup> газрыг, газар эзэмших эрхийг хүчингүй болгох тухай 2 иргэн, ААНБ-ын 2100 м<sup>2</sup> газрыг, захирамжийг холбогдох хэсгийг хүчингүй болгох тухай 3 иргэн, ААНБ-ын, газрын зориулалт өөрчлөх тухай 4 иргэн, ААНБ-ын 6581 м<sup>2</sup> газрыг, газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгах тухай 10 иргэн, ААНБ-ын 17564 м<sup>2</sup> газрыг, Газар эзэмших эрхийг хэсэгчлэн шилжүүлэх тухай 1 иргэний 4035 м<sup>2</sup> газрыг, Шүүхийн шийдвэрээр газар эзэмших эрхийг сэргээх тухай 2 иргэн, ААНБ-ын 11500 м<sup>2</sup> газрыг, Газар эзэмших эрхийг баталгаажуулах тухай 1 иргэний 24 м<sup>2</sup> газрыг, эзэмшиж буй газрын талбайн хэмжээ өөрчлөх тухай 6 иргэн, ААНБ-ын 14351 м<sup>2</sup> газрыг, газар эзэмшүүлэх тухай 1 иргэнд 1200 м<sup>2</sup> газрыг тус тус 30 удаагийн захирамж гарч 53 иргэн, ААНБ-ын өргөдөл хүсэлт шийдвэрлэгдээд байна.

### **Хүнс, үйлдвэр, үйлчилгээ**

Хүнсний нөөцийн сүүлийн 7 хоногийн судалгаагаар гурил 376 тн буюу 48 хоног, гоймон 35.8 тн буюу 3 хоног, будаа 77.1 тн буюу 21 хоног, сахар 70.5 тн буюу 28 хоног, ургамлын тос 21.7 тн буюу 11 хоног, давс 28.6 тн буюу 69 хоног, ундны ус 39 мян.л буюу 1 хоног, хуурай сүү 3.96 тн буюу 3 хоног, төмс 24.9 тн буюу 10 хоног, хүнсний ногоо 10.8 тн буюу 1 хоног, өндөг 1.22 тн буюу 20 хоногийн нөөцтэй байна.

Эрүүл мэндээ хамгаалж эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөний хүрээнд “Ажлын байрыг дэмжих” зээлийг арилжааны банкуудаар дамжуулан олгож байна. Өнөөдрийн байдлаар ажлын байрыг дэмжих зээлийг Хаан банк 117 иргэн, аж ахуйн нэгжид 7,4 тэрбум төгрөг, Төрийн банк 46 иргэн, аж ахуйн нэгжид 9.0 тэрбум төгрөг, Хас банк 21 иргэн, аж ахуйн нэгжид 1.2 тэрбум төгрөг, Голомт банк 20 иргэн, аж ахуйн нэгжид 1,4 тэрбум төгрөгийн зээлүүдийг тус тус олгоод байна. Ажлын байрыг дэмжих зээлийг 154 иргэнд 10,3 тэрбум төгрөг, 50 аж ахуйн нэгжид 9,3 тэрбум төгрөг, нийт 204 иргэн, аж ахуйн нэгжид 19,6 тэрбум төгрөгийн зээл олгож 723 ажлын байрыг хадгалсан байна.

Хөдөө аж ахуйг дэмжих зээлийг олгож эхлээд байгаа бөгөөд 6-р сарын 25-ны байдлаар 1033 малчинд 13,1 тэрбум төгрөг, газар тариалангийн чиглэлээр 1 аж ахуйн нэгжид 120.0 сая, 1 иргэнд 30.0 сая төгрөгийн зээл тус тус олгоод байна.

2020 оны сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт жилийн эцсийн байдлаар 700,8 сая төгрөг орж ирсэн бол 2021 оны сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт энэ оны эхний хагас жилийн байдлаар 989,3 сая төгрөг орж ирсэн байна.

2021 онд сум хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээл Цэнхэр, Хангай, Өндөр-Улаан сумдад 65 иргэн, аж ахуйн нэгжийн төсөлд 240.000.000 сая төгрөгийн зээл олгож 98 ажлын байр бий болсон байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

-----oOo-----